



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/475

Ховд

Эзэмшил газрын хэмжээ, талбай өөрчлөх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/05 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Цагаан уул цогцолборын дэргэд байрлах иргэн Нанзадын Пүрэвдорж /ПЮ47060114/-ийн, үйлчилгээний зориулалттай 200.0 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 162.0 метр квадрат, хаягийг Заны 1 дүгээр гудамжны 113 тоот болгон өөрчлөн, үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

2.Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Цагаан уул цогцолборын дэргэд байрлах иргэн Пүрэвдоржийн Хишигбаяр /ПЮ72112665/-ийн, үйлчилгээний зориулалттай 200.0 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 163.0 метр квадрат, хаягийг Заны 1 дүгээр гудамжны 111 тоот болгон өөрчлөн, үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар

3.Жаргалант сумын Баатархайрхан багийн нутаг дэвсгэр Эсгийн үйлдвэрийн хашаа байрлах иргэн Менепийн Айбол /ПЭ87051814/-ийн, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай 29000.0 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 29132.0 метр квадрат, хаягийг Барилгачдын 5 дугаар гудамжны 511 тоот болгон өөрчлөн, үйлчилгээний зориулалтаар 8 жилийн хугацаагаар,

4. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Музейн баруун талд байрлах Шүүхийн шинжилгээний алба /4065921/-ны албан хэрэгцээний зориулалттай 1490.0 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 1611

Зах А/475 Сх
02 02346

метр квадрат, хаягийг Заны 1 дүгээр гудамжны 106 тоот болгон өөрчлөн, албан хэрэгцээний зориулалтаар 10 жилийн хугацаагаар,

5.Жаргалант сумын Алагтолгой багийн нутаг дэвсгэр Төв бараан захын хойд талд байрлах иргэн Манжилын Ягаан /ПЭ42100200/-ний, эмийн сангийн зориулалттай 90.0 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 120.0 метр квадрат, хаягийг Залуус 4 дүгээр гудамжны 424 тоот болгон өөрчлөн, үйлчилгээний зориулалтаар 10 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

6.Газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

7. Газар эзэмших эрх баталгаажсан иргэн, аж ахуй нэгж байгууллагад газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

